**“ПИЙК ОМ АУДИТ” ХХК**

Монгол улс, Дархан-Уул аймаг, Дархан сум,
10-р баг, Буудай центрийн 602 тоот
Tel: 9986-2066, 99041628
E-mail: peakomauditllc@gmail.com

2025.01.26 № 25/048

**“БУМАН ДУСАЛ ББСБ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**Дүгнэлт**

Бид “БУМАН ДУСАЛ ББСБ” ХХК (“Компани”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

**Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай дотоод хяналтыг бий болгох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасратлгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

**Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх хариуцлага**

Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)**
**“БУМАН ДУСАЛ ББСБ” ХХК -ийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан**

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн батлагаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрвээ тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”- ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

• Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдлийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боовсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдлээс өндөр байдаг.

• Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах

• Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх

• Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйлд явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрвээ материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл бидний олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

• Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлэх, мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

**Бусад зүйл**
Энэхүү тайланг Монгол улсын Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан ба өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**ЗАХИРАЛ** **Б.ЖАРГАЛСАЙХАН**

**"БУМАН ДУСАЛ ББСБ" ХХК**
**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
**/2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/**

/төгрөг/

| Үзүүлэлт | | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Санхүүгийн хөрөнгө** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | | 685,462,815.08 | 939,279,391.11 |
| Зээл | | 12,497,169,165.68 | 25,091,089,915.41 |
| Факторингийн тооцооны авлага | | | |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | | | |
| Хөрөнгө оруулалт | | | |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | | |
| **Санхүүгийн хөрөнгийн дүн** | | **13,182,631,980.76** | **26,030,369,306.52** |
| **Санхүүгийн бус хөрөнгө** | | | |
| Татвар, НДШ-ийн авлага | | 238,514.68 | 1,100,000.11 |
| Үндсэн хөрөнгө | | 68,746,566.07 | 49,089,051.34 |
| Биет бус хөрөнгө | | 56,247,311.67 | 51,062,738.24 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | | |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | | 53,561,435.77 | 8,353,140.16 |
| **Санхүүгийн бус хөрөнгийн дүн** | | **178,793,828.19** | **109,604,929.85** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **13,361,425,808.95** | **26,139,974,236.37** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр | | 3,385,490,144.26 | 8,444,698,550.00 |
| Банк санхүүгийн байгууллагаас татсан үүсвэр | эх | 988,911,999.99 | 6,913,014,662.56 |
| Бусад эх үүсвэр | | | |
| Үүсмэл санхүүгийн өр төлбөр | | | |
| Бусад санхүүгийн өр хөрөнгө | | 374,366,089.27 | 44,764,203.94 |
| Хоёрдогч өглөг | | | |
| Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр) | | | |
| **Санхүүгийн өр төлбөрийн дүн** | | **4,748,768,233.52** | **15,402,477,416.50** |
| **Санхүүгийн бус өр төлбөр** | | | |
| Татвар, НДШ-ийн өр төлбөр | | 165,363,004.22 | 254,120,833.45 |
| Нөөц (Болзошгүй өр төлбөр) | | | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | | | |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | | | |
| **Санхүүгийн бус өр төлбөрийн дүн** | | **165,363,004.22** | **254,120,833.45** |
| **Өр төлбөрийн дүн** | | **4,914,131,237.74** | **15,656,598,249.95** |
| **ӨМЧ** | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | | 5,265,540,000.00 | 6,112,320,000.00 |
| Өмчийн бусад хэсэг | | 3,683,000.00 | 3,683,000.00 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | | 3,178,071,571.21 | 4,367,372,986.42 |
| **Өмчийн дүн** | | **8,447,294,571.21** | **10,483,375,986.42** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | | **13,361,425,808.95** | **26,139,974,236.37** |

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР:

НИЙЦ ОМ АУДИТ ХХК

**"БУМАН ДУСАЛ ББСБ" ХХК**
**АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН**
**/2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/**

/төгрөг/

| Үзүүлэлт | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| **Хүүгийн орлого** | | |
| Банкинд байршуулсан хөрөнгийн | 275,159.47 | 11,209,709.39 |
| Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | | |
| Зээлийн | 3,366,146,196.22 | 6,199,405,126.89 |
| Үнэт цаасны | | |
| Бусад | | |
| (Хүүгийн орлогын буцаалт) | | |
| **Хүүгийн орлогын дүн** | **3,366,421,355.69** | **6,210,614,836.28** |
| **Хүүгийн зардал** | | |
| Итгэлцлийн үр шим | 525,033,156.19 | 1,102,559,119.20 |
| Зээлийн | 191,597,752.63 | 654,813,136.83 |
| Үнэт цаасны | | |
| Бусад | | |
| (Хүүгийн зардлын буцаалт) | | |
| **Хүүгийн зардлын дүн** | **716,630,908.82** | **1,757,372,256.03** |
| **Хүүгийн цэвэр орлого** | **2,649,790,446.87** | **4,453,242,580.25** |
| Эрсдэлийн сангийн зардал | 182,508,799.02 | 494,747,570.99 |
| **Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого** | **2,467,281,647.85** | **3,958,495,009.26** |
| **Бусад орлого** | **103,182,058.27** | **288,175,365.05** |
| Хүүгийн бус орлого | 49,246,925.00 | 86,409,691.00 |
| Бусад орлого, олз | 53,935,133.27 | 201,765,674.05 |
| **Бусад зардал** | **438,363,517.52** | **789,123,627.02** |
| Хүүгийн бус зардал | 429,795,366.21 | 737,218,815.09 |
| Бусад зардал, гарз | 8,568,151.31 | 51,904,811.93 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **2,132,100,188.60** | **3,457,546,747.29** |
| Орлогын татварын зардал | 214,059,734.47 | 350,236,282.08 |
| **Татварын дараах ашиг алдагдал** | **1,918,040,454.13** | **3,107,310,465.21** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал** | **1,918,040,454.13** | **3,107,310,465.21** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| **Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн** | **1,918,040,454.13** | **3,107,310,465.21** |

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР:

ТИЙК ОМ АУДИТ ХХК

**"БУМАН ДУСАЛ ББСБ" ХХК**
**АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**
**/2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/**

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмч | Эздийн өмчийн бусад хэсэг | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Бусад өөрийн хөрөнгө | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2023 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл** | **2,627,170,000.00** | | **3,683,000.00** | | **4,813,776,816.01** | **7,444,629,816.01** |
| *Нягтлан бүртгэлийн бодлогын өөрчлөлтйн нөлөө алдааны залруулга* | | | | | | - |
| *Залруулсан үлдэгдэл* | 2,627,170,000.00 | | 3,683,000.00 | | 4,813,776,816.01 | **7,444,629,816.01** |
| *Тайлант үеийн цэвэр ашиг* | | | | | 1,918,040,454.13 | **1,918,040,454.13** |
| *Бусад дэлгэрэнгүй орлого* | | | | | 11,290.07 | **11,290.07** |
| *Өмчид гарсан өөрчлөлт* | | | | (915,386,989.00) | | **(915,386,989.00)** |
| *Хуваарилсан ногдол ашиг* | 2,638,370,000.00 | | | 915,386,989.00 | (3,553,756,989.00) | - |
| **2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **5,265,540,000.00** | - | **3,683,000.00** | - | **3,178,071,571.21** | **8,447,294,571.21** |
| *Нягтлан бүртгэлийн бодлогын өөрчлөлтйн нөлөө алдааны залруулга* | | | | | | - |
| *Залруулсан үлдэгдэл* | 5,265,540,000.00 | - | 3,683,000.00 | - | 3,178,071,571.21 | **8,447,294,571.21** |
| *Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал* | | | | | 3,107,310,465.21 | **3,107,310,465.21** |
| *Бусад дэлгэрэнгүй орлого* | | | | | 31,450.00 | **31,450.00** |
| *Өмчид гарсан өөрчлөлт* | | | | (1,071,229,050.00) | | **(1,071,229,050.00)** |
| *Хуваарилсан ногдол ашиг* | 846,780,000.00 | | | 1,071,229,050.00 | (1,918,040,500.00) | **(31,450.00)** |
| *Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн* | | | | | | - |
| **2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **6,112,320,000.00** | | **3,683,000.00** | - | **4,367,372,986.42** | **10,483,375,986.42** |

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР:

МОНГОЛИА
ДАРХАН УУЛ АЙМАГ
НИЙК ОМ АУДИТ ХХК
AUDIT LLC

**"БУМАН ДУСАЛ ББСБ" ХХК**
**АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
**/2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/**

/төгрөг/

| Үзүүлэлт | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан | 3,403,001,644.33 | 24,916,184,129.67 |
| Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан | 3,128,735,233.00 | 4,584,724,579.73 |
| Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан | | |
| Факторингийн үйл ажиллагааанаас хүлээн авсан | | |
| Бусад | 18,725,308,563.83 | 17,146,749,293.51 |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **25,257,045,441.16** | **46,647,658,002.91** |
| Олгосон зээл | 19,937,205,000.00 | 31,710,917,000.00 |
| Буцаан олгосон итгэлцэл, үр шим | 387,310,782.45 | 1,385,343,481.49 |
| Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн | | |
| Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн | | |
| Ажиллагсдад олгосон | 252,110,135.44 | 967,650,000.00 |
| Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 571,134,058.97 | 570,303,247.95 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 3,186,673.77 | 3,687,449.88 |
| Бусад | 5,285,291,532.27 | 17,106,652,581.61 |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **26,436,238,182.90** | **51,744,553,760.93** |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,179,192,741.74)** | **(5,096,895,758.02)** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан | | 7,000,000.00 |
| Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан | | |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан | | |
| Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан | | |
| Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **-** | **7,000,000.00** |
| Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 78,672,935.00 | 38,554,700.00 |
| Хөрөнгө оруулалтаас олж эзэмшихэд төлсөн | | |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн | | |
| Бусад | | |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **78,672,935.00** | **38,554,700.00** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(78,672,935.00)** | **(31,554,700.00)** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| Банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан | 11,138,536,679.44 | 28,663,394,611.29 |
| Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан | | |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| Бусад | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **11,138,536,679.44** | **28,663,394,611.29** |
| Банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрийн зээлд төлсөн | 10,291,683,172.39 | 23,281,127,577.24 |
| Хоёрдогч өглөгт төлсөн | | |
| Төлсөн ногдол ашиг | | |
| Бусад | | |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **10,291,683,172.39** | **23,281,127,577.24** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **846,853,507.05** | **5,382,267,034.05** |
| **Валютын ханшийн зөрүү** | | |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(411,012,169.69)** | **253,816,576.03** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **1,096,474,984.77** | **685,462,815.08** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **685,462,815.08** | **939,279,391.11** |

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР:

